



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20... он... дугаар
сарын...-ны өдөр

Дугаар *Хэг/245*

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БЯМБАЦОГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Дэлхийн худалдааны байгууллагын олон талт хэлэлцээрийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: *13* хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



[Handwritten signature]
Ц.НЯМДОРЖ

000225001880

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ НАРААС МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Асуулга 1. Монгол Улсаас Оросын Холбооны Улсад экспортолж буй гол нэрийн бараа бүтээгдэхүүнд ногдуулж буй импортын татвар, НӨАТ, онцгой албан татвар, хураамж, тоон хязгаарлалтын талаар:

Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ)-ны Гаалийн хуулийн хуулийн 46 дугаар зүйлийн дагуу ОХУ-ын Импортын гаалийн татварын хувь хэмжээ нь дараах 3 төрөлтэй байна. Үүнд:

- Гаалийн үнээс хувиар тооцох, Тухайлбал: 5% ; 10% ; 15%;
- Барааны тоо хэмжээ, жин зэргээс тооцох, Тухайлбал : 1 кг тутамд 0.2 евро;
- Холимог (дээрх 2 төрлийн холимог), Тухайлбал: 5 хувь, гэхдээ 1 кг тутамд 0.2 еврогоос ихгүй;

Импортын бараанд тооцох Нэмэгдсэн өртгийн албан татвар: ОХУ-ын Татварын хуулийн 164 дүгээр зүйлийн 164.1, 164.2, 164.3-т НӨАТ-ын хувь хэмжээ болон түүнд хамаарах барааны жагсаалтыг тус тус заасан байдаг. Үүнд:

- Экспортын, гаалийн чөлөөт бүсийн, реэкспортын горимд байршсан бараа гэх мэт барааны экспортод нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй (0%);
- Хүнсний бараа (мах, өндөг, гурил, масло, давс, гоймон гэх мэт/, хүүхдийн бараа /гутал, тоглоом, дэвтэр гэх мэт), бүтээгдэхүүн, тогтмол хэвлэл, эмийн зүйлс 10%;
- Дээрх 2 заалтад багтаагүй бусад бараа бүтээгдэхүүнүүд 20%.

Татварын хөнгөлөлт: Евразийн эдийн засгийн холбооны Зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн №17 дугаар шийдвэрийн дагуу тарифын хөнгөлөлт эдлэх улс орнуудын жагсаалтыг баталсан ба Монгол Улс “хөгжиж буй орны” жагсаалтад багтдаг тул Барааны импортын гаалийн татварын 75%-иар чөлөөлөгддөг.

ОХУ-ын тарифын хөнгөлөлтөд хөгжиж буй улс орнуудаас импортлох нийт 65 нэр төрлийн барааны жагсаалтыг Евразийн эдийн засгийн комиссын Зөвлөлийн шийдвэрийн дагуу баталсан. Тус хөнгөлөлтийг олгохдоо Гарал үүслийн гэрчилгээ Форма “А”-г үндэслэнэ. Гарал үүслийн гэрчилгээ Форма “А”-г Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас олгодог.

Тарифын хөнгөлөлт эдлэх барааны жагсаалт: Хөгжиж буй орны гарал үүслийн жагсаалтад нийт 65 нэр төрлийн бараа багтана. Тухайлбал, мах, махан бүтээгдэхүүн (гахайн мах, шувууны махнаас бусад), сүүн бүтээгдэхүүн, амьтны гаралтай бүтээгдэхүүн, өндөг, зөгийн бал, кофе, цай, будаа, үр тариа, эфирийн тос, зарим төрлийн эмийн зүйлс, керамик эдлэл, самнаагүй ноос, модон материал, торго, хөвөн даавуу.

ОХУ-аас Монгол Улсын экспортын гол нэр төрлийн бараанд дараах гаалийн импортын татварыг ногдуулж байна.

№	Бүтээгдэхүүний нэр	ОХУ-ын импортын гаалийн татвар
1.	Хонь, ямааны шинэ, хөргөсөн эсхүл хөлдөөсөн мах, адууны мах	15 хувь, гэхдээ 1 кг нь 0.15 еврогоос багагүй байх
2.	Үхрийн хөлдүү мах	15 хувь, 55 хувь /тарифын квоттой/
3.	Хонь, ямааны боловсруулсан арьс	5 хувь
4.	Ямааны угаасан, угаагаагүй, самнасан болон бөмбөгөн ноолуур	5 хувь
5.	Малын дайвар бүтээгдэхүүн: үхрийн шинэ, хөргөсөн болон хөлдөөсөн дайвар бүтээгдэхүүн (хэл, элэг), адуу, хонь, ямааны дайвар бүтээгдэхүүн	0-15 хувь, гэхдээ 1 кг нь 0.6-0,15 еврогоос багагүй байх
6.	Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	12.5, 15 хувь
7.	Зэсийн хүдэр, баяжмал	3 хувь
8.	Молибдены хүдэр, баяжмал	0 хувь
9.	Хээрийн болон хайлуур жонш	5 хувь
10.	Свитер, пуловер, джемпер, жилет болон сүлжмэл гадуур цамц	10 хувь, гэхдээ 1 кг нь 1.5 еврогоос багагүй байх (зарим бүтээгдэхүүн 1 кг тутам 1,75 евро)

ДХБ-ын гишүүний хувьд ОХУ нь бусад гишүүн улсуудаас импортлох бараанд нэн тааламжтай үндэсний нөхцөл олгохоос гадна хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүн /шинэ, хөргөсөн, хөлдөөсөн үхэр, шувууны мах, шар сүү/-дээ тарифын квот /тоон хязгаарлалт/ тогтоосон. Жишээлбэл, үхрийн шинэ болон хөлдөөсөн махны импортын квот дотор мөрдөх тариф нь 15 хувь, харин квотоос давсан тохиолдолд 55 хувийн тарифтай.

Гаалийн үйлчилгээний хураамжийг дараах аргаар тодорхойлж, импортын бараанд ногдуулдаг.

200 мянга болон түүнээс доош рублийн өртөгтэй бараа тутмаас	775 рублийн хураамж
200-450 мянган рублийн өртөгтэй бараанаас	1550 рублийн хураамж
450 мянгаас - 1.2 сая рублийн өртөгтэй бараанаас	3100 рублийн хураамж
1.2-10 сая рублийн өртөгтэй бараанаас	8530-27000 рублийн хураамж
10 саяас дээш рублийн өртөгтэй бараанаас	30000 рублийн хураамж

Гаалийн үнийг тодорхойлох боломжгүй бараанд дараах байдлаар үйлчилгээний хураамжийг ногдуулна. Үүнд: 50 болон түүнээс доош ширхэг бараанд 6000 рубль, 51-100 ширхэг бараанд 12000 рубль, 101-ээс дээш ширхэг бараанд 20000 рубль. Мөн агаарын хөлөг, далай, усан замын хөлөг тус бүрт 20500 рубль ногдуулдаг.

Гаалийн эскортын хураамжийг дараах аргаар тодорхойлж, ногдуулдаг. Үүнд:

Хөдөлгүүрт машин, төмөр замын тээвэр	
50-200 км хүртэл	2000-4000 рубль
200 км-ээс дээш	100 км тутам 1000 рубль
Далай, усан замын тээвэр, агаарын хөлөг	Тээврийн хэрэгсэл тус бүр 20000 рубль

Гаалийн агуулахын хураамжийг дараах байдлаар тооцдог. Үүнд:

Түр зуурын гаалийн агуулах	100 кг ачаа тус бүр 1 өдөрт 1 рубль
Тусгай тоногдсон агуулах	100 кг ачаа тус бүр 1 өдөрт 2 рубль

Акциз буюу онцгой албан татварын хувь хэмжээ. Үүнд:

Бүх төрлийн түүхий эдээр хийсэн этилийн спирт болон спиртийн агууламж бүхий бүтээгдэхүүн (үнэртэй ус, косметик, гэр ахуйн химийн бүтээгдэхүүнээс бусад)	1 литр тутам 566 рубль
Усан үзмээр хийсэн дарс	Тонн тутам 31 рубль
Дарсны орцод усан үзэм, жимс орсон	Литр тутам 32 рубль
Этилийн спиртийн агууламж 9% болон түүнээс хэтрэхгүй согтууруулах бүтээгдэхүүн	Литр тутам 452 рубль
Этилийн спиртийн агууламж 9% болон түүнээс дээш согтууруулах бүтээгдэхүүн	Литр тутам 566 рубль
Оргилуун дарс болон бусад дарс	Литр тутам 41-32 рубль
Хүнсэнд суурилсан этилийн спирт нэмэлгүйгээр хийсэн дарс ундаа	Литр тутам 41 рубль
Алимны, лийрийн, зөгийн балны исгэсэн ундаа, этилийн спиртийн агууламж 0.5% болон түүнээс хэтрэхгүй шар айраг, этилийн спиртийн агууламж бүхий шар айраг	Литр тутам 0-43 рубль
Тамхины бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалттай орцоос бусад тамхи татах, зажлах, хоолой, усны хоолой бүхий тамхи (хөөрөг гэх мэт) болон халаах замаар хэрэглэх тамхи	Кг тутам 3806-7248 рубль
Никотин хүргэх электрон систем, тамхи халаах төхөөрөмж	Ширхэг тутам 60 рубль
Никотин дамжуулах цахилгаан системийн шингэн	Мл тутам 16 рубль
Сигар	Ширхэг тутам 258 рубль
Тамхи	1000 ширхэг тутам 2359-3666 рубль + 16% (гэхдээ 1000 ширхэг тутам 3205 рублиас багагүй байх)
Хөдөлгүүрийн хүч 67.5-375 квт-ын хүчин чадалтай машин, 112.5 квт-аас дээш хүчин чадалтай мотоцикл	0.75 квт тутам 51 -1464 рубль
Байгалийн хий	30 хувь
Бензин /5 дугаар ангиллын болон бусад/, дизель түлш, дизель ба/эсвэл карбюратор (шахах) хөдөлгүүрт зориулсан тос, Virgin бензин, бензол,	Тонн тутам 5841-15533 рубль

паракилол, ортоксилен, тийрэлтэт хөдөлгүүрийн керосин	
Завсрын нүүрс-устөрөгчийн нэрэлт, газрын тос	Формула

Импортын хориг, хязгаарлалт, лизенз: ОХУ-ын зүгээс 2014 оны 8 дугаар сард тодорхой нэр төрлийн хөдөө аж ахуйн барааг (амьд гахай, үхрийн шинэ эсвэл хөргөсөн мах, хонь, ямаа, адуу, илжиг, луус болон сүү, сүүн бүтээгдэхүүн гэх мэт) зарим орноос (Албани, Австрали, Канад, ЕХ, Исланд, Лихтенштейн, Монтенегро, Норвеги, Украин, Их Британи, АНУ) импортлохыг хориглосон шийдвэр гаргасан бөгөөд одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Бусад арга хэмжээ: Оросын эсрэг хориг арга хэмжээ авсан орнуудын барааг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхийг ОХУ-ын зүгээс 2014 онд бүрэн хориглосон бөгөөд 2019 оны 7 дугаар сард энэ хоригийг цуцалсан. Гэхдээ ачааг ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжин тээвэрлэхэд ГЛОНАСС пломбыг заавал тавиулах шаардлага тавьж байна. Мөн 2020 оны 6 дугаар сараас агаарын замаар дамжин өнгөрч буй бараанд энэ пломбыг тавиулах шаардлага тавьж байгаа.

ДХБ-аас бэлтгэсэн ОХУ-ын худалдааны бодлого, зохицуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж үзнэ үү.

www.wto.org/dol2fe/Pages/SS/directdoc.aspx?filename=c:/WT/TPR/S416.pdf&Open=True

Асуулга 2. Монгол Улсаас экспортолж буй гол нэрийн бараа бүтээгдэхүүний тээврийн гаалийн тарифыг дээр дурдсан болон бусад олон улсын гэрээгээр хэрхэн зохицуулсан, тухайлбал, ДХБ-ын хэлэлцээрүүдийн хүрээнд олгож буй хөнгөлөлт, Монгол Улсад олгогдож буй давуу тал, тулгарч буй бэрхшээл сорилтын талаар:

Дэлхийн худалдааны байгууллага нь худалдаанд учирч буй элдэв саад тотгорыг багасгах, худалдааг зөвхөн тарифаар хязгаарлах, улмаар тарифаа багасгах, цаашлаад тэглэх үүргийг гишүүн орнууддаа хүлээлгэх замаар худалдааг чөлөөтэй болгох зорилго бүхий олон улсын байгууллага юм. Өнөөдрийн байдлаар ДХБ-д 164 орон гишүүнээр элссэн бөгөөд 30 гаруй улс, олон улсын 60 гаруй байгууллага ДХБ-д ажиглагчийн статустай. Протокол соёрхон батлах тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар "Монгол Улс, Дэлхийн худалдааны байгууллагын хооронд 1996 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан "Дэлхийн худалдааны байгууллага байгуулах Марракешийн Хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол"-ыг соёрхон баталсан. Монгол Улсын хувьд гэрээ 1997 оны 1 дүгээр сарын 29-нд хүчин төгөлдөр болсон. Энэхүү гэрээний хүрээнд Монгол Улс ДХБ-ын гишүүн орнуудаас дараах хөнгөлөлтийг эдлэх эрхтэй болсон. Үүнд:

- *Худалдааны хөнгөлөлттэй зохицуулалтууд:* Энэ нь ДХБ-ын аль нэг гишүүн худалдааны аль нэг түншдээ дангаараа олгож болох бага буюу тэг хувьтай тариф зэрэг худалдааны хөнгөлөлтийн тухайд ДХБ-д ашигладаг нэр томьёо юм. Үүнд Хөнгөлөлтийн ерөнхий систем хамаарна. Энэ системийн дагуу хөгжингүй орнууд хөгжиж буй орнуудаас импортлох бараанд хөнгөлөлттэй тариф мөрдөх боломжийг олгодог;

- *Хөнгөлөлтийн ерөнхий систем:* Хөгжиж буй орнуудаас хөгжингүй орнуудад импортлох бараанд гаалийн татварын багасгасан хувь хэмжээгээр татвар ногдуулдаг, эсхүл гаалийн татваргүй нэвтрүүлдэг гаалийн хөнгөлөлтийн систем; Хөнгөлөлтийн ерөнхий систем нэвтрүүлэх ДХБ-ын эрх зүйн үндэс болох “эрх олгосон заалт”-ын үндсэн дээр нэн тааламжтай нөхцөлөөс бүрмөсөн татгалзах замаар энэхүү хөнгөлөлтийн системийг нэвтрүүлдэг;
- *Үндэсний нэн тааламжтай нөхцөл:* ДХБ-ын аль нэг Гишүүн ДХБ-ын өөр аль нэг Гишүүний тодорхой бараанд үндэсний нэн тааламжтай нөхцөл олгосон бол тэр нь ДХБ-ын бусад бүх Гишүүдтэй хийх худалдаанд нэгэн адил хамаарна. Энэ зарчим нь Хөнгөлөлтийн ерөнхий систем болон чөлөөт худалдааны бүс, гаалийн холбоонд хамаарахгүй;
- *Үндэсний нөхцөл:* Импортын бараанд дотоодын үйлдвэрлэлийн барааны адил болзол, шаардлага тавина гэсэн үг юм. Энэ нь одоогоор тухайн импортын барааг оруулсны дараах техникийн стандарт, аюулгүй байдлын стандарт зэрэгт хамаарч байна.

“ДХБ байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол”-д дурдсан шаталсан хугацаа бүхий үүрэгтэй холбоотой нарийвчилсан мэдээллийг www.wto.org/english/thewto_e/countries_e/mongolia_e.htm линкээр орж үзнэ үү.

Асуулга 3. Монгол Улсын гол нэрийн бараа бүтээгдэхүүнийг гуравдагч зах зээлд экспортлохоор ОХУ ба БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд төмөр замын тарифын хэлэлцээр хэрэгжихгүй байгаагийн гол учир шалтгаан юу байна вэ? Тээврийн тариф болон тарифын бус саад тотгор, дээр дурдсан хэлэлцээр буюу тохиролцоо хэрэгжиж байгаа эсэх, хүндрэл бэрхшээлийн шалтгаан дээрх хэлэлцээрээс үүдэлтэй эсэх талаар:

БНХАУ-ын талтай: Шинээр дөрвөн төмөр замын боомтыг нэмж байгуулах үүнээс эхний ээлжид Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ боомтыг байгуулахаар “Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай” Монголын Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2014 онд байгуулсан.

Тус хэлэлцээрийг манай улс 2015 оны 01 дүгээр сард соёрхон баталсан боловч хятадын талаас дотоодын процесс гүйцээгүй гэсэн шалтгаанаар соёрхон батлаагүй байна. Үүний улмаас Монголын бүтээгдэхүүний гуравны нэгтэй тэнцэхүйц хэмжээний ачааг гуравдагч орон руу БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх тээвэрлэлтийн хүчин чадлаар хангах, олон улсын Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын Нэгдсэн нэвтрэх тарифын мөрдлөгөөс 40 хувийн хөнгөлөлт үзүүлнэ гэсэн заалтууд хэрэгжих боломжгүй байна. Иймээс Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ төмөр замын боомтыг байгуулахаар ажиллаж байна.

Мөн харилцан ашигтай, эрх тэгш дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд Монголын тал Хятад-Европ чиглэлийн чингэлгийн буухиа галт тэргийг хөнгөлөлттэй тарифаар тээвэрлэж байгааг харгалзан одоо үйл ажиллагаа явуулж байгаа төмөр замын Замын-Үүд-Эрээн боомтоос БНХАУ-ын гадаад худалдаанд нээлттэй далайн боомтууд руу болон эсрэг чиглэлийн дамжин өнгөрөх

тээвэрт хятадын тал адил хэмжээний хөнгөлөлттэй тариф үзүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах саналыг Хятадын талд хүргүүлээд байна.

ОХУ-ын талтай: “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай” Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2018 онд байгуулсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байна. Тус хэлэлцээрт хоёр улсын нутаг дэвсгэрээр төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрт тарифын уян хатан бодлого баримтлах, төмөр замын ачаа тээвэрт бусад чиглэлүүдтэй харьцуулахад өрсөлдөхүйц тарифын нөхцөлийг урт хугацаанд хангах, төмөр замаар тээвэрлэж буй ачааг улсын хилээр нэвтрүүлэх ажиллагааг хөнгөвчлөх нөхцөлийг бүрдүүлэх, хоёр улсын төмөр замын ачаа тээврийн өсөлтийг хөхиүлэн дэмжих, ачаа тээврийн өсөлтийн эрчим болон төмөр замын тээврийн суурь бүтцийн хөгжлийн харилцан уялдааг хангахаар тусгасан.

Хэлэлцээрийн үр дүнд “Оросын төмөр замууд” НХН-ээс 1 жилийн хугацаагаар олгож буй тарифын хөнгөлөлтийг 25 жилийн хугацаанд баталгаажуулж аваад байна. Ингэснээр уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг гуравдагч улсын зах зээлд гаргахад экспортын үнийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, уул уурхай, үйлдвэрлэлийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татаж урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах төлөвлөх таатай нөхцөлийг бүрдүүлэх суурь болж өгч байна. Монгол Улс ОХУ-аас дамжин өнгөрөх нүүрсний тээвэрт Нэгдсэн нэвтрэх тарифаас 66.4%, чингэлэг тээвэрт 52%-ийн хөнгөлөлт авч байна. Өнөөдрийн байдлаар хэлэлцээрээс үүдэлтэй хүндрэл бэрхшээл үүсээгүй байна.

Асуулга 4. Монгол Улс, БНХАУ, ОХУ нь ДХБ-ын гишүүний хувьд манай улсын экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүнийг хөрш улсад экспортлоход ДХБ-ын хүрээнд тарифын болон тарифын бус ямар хөнгөлөлт эдэлж, манай улс ямар үүрэг хүлээдэг талаар:

Монгол Улс хөрш орнуудтай ДХБ, ДГБ-аас батлан гаргасан гадаад худалдаа, гаалийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн хүрээнд хамтран ажиллах боломжтой. Гаалийн тариф нь ДХБ-д нэгдэн орохдоо улс орнуудын авсан үүрэг амлалт буюу тааз тарифын хэмжээнээс хамаарна. ДГБ-аас батлан гаргасан олон улсын гэрээ, хэлэлцээр, бодлогын баримт бичгийг харьцуулсан гол зорилго нь улс хооронд хийгдэх хил дамнасан худалдаанд хяналт тавих үндсэн чиг үүргийг гаалийн байгууллага хэрэгжүүлдэг. Иймд гурван улсын гаалийн үйл ажиллагааг¹ уялдуулснаар худалдааны эргэлтийг түргэсгэх, худалдааг хөнгөвчлөх боломж бүрдэх юм.

Өөрөөр хэлбэл гаалийн байгууллагын чиг үүрэгт худалдааг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах бодлого хамаарах тул эдгээр байгууллагын үйл ажиллагааг уялдуулснаар Монгол Улсын гадаад худалдаа өсөн нэмэгдэх, мөн гаалийн зарим горимын тусламжтай (Тухайлбал, гаалийн баталгаат бүс, чөлөөт бүс, барааг дотоодод болон гадаадад боловсруулах гаалийн горим) эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой юм.

¹ ДГБ-ын “Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай” конвенцид “Гаалийн хуулийн хэрэгжилтийг хангуулах, гаалийн болон бусад татварыг хураан авах, мөн импорт, экспорт болон барааны хадгалалт, хөдөлгөөнтэй холбоотой бусад хууль, журмуудыг мөрдөх чиг үүрэг бүхий Засгийн газрын үйлчилгээний албыг хэлнэ.” гэж тодорхойлсон.

Гаалийн үйл ажиллагааг уялдуулахад ДГБ, ДХБ-аас гаргасан бодлогын баримт бичгийн хүрээнд ажиллах нь чухал, үр дүнтэй юм. Дараах хүснэгтэд гадаад худалдаатай холбоотой ДГБ, ДХБ-аас гаргасан гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон огноог харьцуулан үзүүлээ.

*Хүснэгт 1. ДГБ, ДХБ-аас гаргасан зарим гэрээ, хэлэлцээр, бодлогын гол баримт бичигт Монгол Улс, ОХУ, БНХАУ нэгдэн орсон байдал**

Д/Д	Баримт бичгийн нэр	Монгол Улс	ОХУ	БНХАУ
1	ДГБ-ын “Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай Конвенц” (ДГБ байгуулах тухай Конвенц)	1991	1991	1983
2	ДГБ-ын “Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Системийн конвенц”	1993	1997	1993
3	ДГБ-ын “Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын Конвенц”	2006	2002	2001
4	ДГБ-ын “Дэлхийн худалдааг аюулгүй байлгах хөнгөвчлөх багц стандарт”	2005	2005	2005
5	ДХБ-ын “Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээр” (Дэлхийн Худалдааны Байгууллагын Хэлэлцээр, Марракешийн Хэлэлцээр)	1997	2012	2011
6	ДХБ-ын “ТХЕХ-ийн 1994 оны VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр” (Үнэлгээний Хэлэлцээр)	1997	2012	2011
7	ДХБ-ын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”	2016	2016	2015

*гэрээ хүчин төгөлдөр болсон огноо

Эх сурвалж: ДГБ (ДГБ, 2019), ДХБ-ын албан ёсны цахим хуудас (ДХБ, 2019)

Хүснэгт 2. Монгол Улсын гадаад худалдаа, гаалийн үйл ажиллагаанд мөрдөж буй олон улсын гэрээ, хэлэлцээр

No	Гэрээний нэр	Хүчин төгөлдөр болсон өдөр	Монгол Улсад хүчин төгөлдөр болсон өдөр
ДЭЛХИЙН ГААЛИЙН БАЙГУУЛЛАГААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАРИМТ БИЧГҮҮД			
1.	Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай Конвенц (Дэлхийн гаалийн байгууллага байгуулах тухай Конвенц, 1950-12-15. Бельги Улсын Брюссель хот)	1952-11-04	1991-09-17
2.	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын Конвенц (БТКУС-ийн Конвенц, 1983-06-14. Бельги Улсын Брюссель хот)	1988-01-01	1993-01-01

No	Гэрээний нэр	Хүчин төгөлдөр болсон өдөр	Монгол Улсад хүчин төгөлдөр болсон өдөр
3.	Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын Конвенц (Киотогийн Конвенц, 1973-05-18. Япон Улсын Киото хот)	1974-09-25	2006
4.	Түр хугацаагаар оруулах тухай Конвенц (Стамбулын Конвенц, 1990-06-26. Турк Улсын Стамбул)	1993-11-27	2003-09-05
ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН БАРИМТ БИЧГҮҮД			
5.	Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээр (Дэлхийн Худалдааны Байгууллагын Хэлэлцээр, Марракешийн Хэлэлцээр, 1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01	1997-01-29
6.	1994 оны ТХЕХ-ийн VI зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (Демпингийн эсрэг татварын тухай Хэлэлцээр, 1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01	1997-01-29
7.	1994 оны ТХЕХ-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (Дэлхийн Худалдааны Байгууллагын Үнэлгээний Хэлэлцээр, 1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01	1997-01-29
8.	Ачилтын өмнөх шалгалтын тухай Хэлэлцээр (1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01	1997-01-29
9.	Гарал үүслийн дүрмийн тухай Хэлэлцээр (1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01	1997-01-29
10.	Татаас болон нөхөн төлөөсийн/ саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээр (1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01	1997-01-29
11.	Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр (Бали, Сайд нарын Бага хурал, 9 дүгээр хуралдаан 2013 оны 12 дугаар сарын 3-6)	2017-02-22	2016-11-24
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГААС ХЯНАЛТ ТАВИН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАРИМТ БИЧГҮҮД			
12.	Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын Конвенц (Парисын Конвенц) 1883-03-20. Франц Улсын Парис хот	1884-07-07	1985-04-21
13.	Олон улсын хэмжээнд бараа худалдах, худалдан авах гэрээний тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц 1980-4-11. Австри Улсын Вена хот	1988-01-01	1999-01-01
14.	Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (Женевийн Конвенц) 1982-10-21. Швейцар Улсын Женев хот	1987-09-12	2007-05-04

No	Гэрээний нэр	Хүчин төгөлдөр болсон өдөр	Монгол Улсад хүчин төгөлдөр болсон өдөр
15.	Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр	2016-04-23	2016-02-05
16.	ТИР карней ашиглан олон улсын хэмжээнд бараа тээвэрлэх тухай Конвенц (ТИР Конвенц) 1975-11-14. Швейцар Улсын Женев хот	1978	2003-04-01

Хүснэгт 3. Хөрш орнуудтай байгуулсан олон улсын хоёр талт гэрээ (Гадаад худалдаа, хилийн боомттой холбоотой зарим баримт бичгээс)

№	Утга	Гэрээ байгуулсан огноо
I. Гаалийн хүрээнд хамтран ажиллах, харилцан туслах тухай асуудлаар		
1.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	1993-01-20
2.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	1993-09-07
II. Хил, хилийн боомтын асуудлаар		
1.	Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	1994-08-10
2.	Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	2004-07-05
3.	Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ	2006-12-08
4.	Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ	2010-06-01
III. Бусад асуудлаар		
1.	БНМАУ, БНХАУ-ын хоорондын консулын Конвенц	1986-08-09
2.	Монгол Улс, ОХУ-ын нутгаар дамжин тээвэр хийж, далайд гарах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	1992-10-19

Дээрх хүснэгтэд үзүүлсэн гэрээ, хэлэлцээр, стандартын хүрээнд гурван улсын хооронд гадаад худалдааны бодлого, гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах боломж олон улсын түвшинд бүрдсэн болох нь харагдаж байна.

Монгол Улс өөрийн гадаад худалдааны гол түнш орнуудтай зөвхөн хоёр талт хамтын ажиллагаагаар хязгаарлагдахгүй, олон улсын түвшинд хамтран ажиллах боломжтой. Монгол Улс анх ДХБ-д анх элсэн орохдоо импортын барааны гаалийн тарифын хэмжээг багаар тогтоосон болох нь дараах хүснэгтэд үзүүлсэн харьцуулсан мэдээллээс харагдаж байна.

Хүснэгт 4. Импортын барааны гаалийн тарифын хувь хэмжээ (2020 он, БНХАУ, ОХУ, Монгол Улс)

Импортын тарифын хувь хэмжээ	БНХАУ	ОХУ	Монгол
Хамгийн өндөр тариф (%)	695.50	100	40
Энгийн дундаж тариф (%)	7.56	4.92	5.04
Худалдааны жигнэсэн дундаж тариф (%)	3.39	3.51	5.26

Эх сурвалж: The World Integrated Trade Solution software (Software, 2020)

Монгол Улсын гадаад худалдааны гол түнш орнуудад мөрдөх импортын барааны гаалийн тарифын хувь хэмжээ нь харилцан адилгүй байна. Өөрөөр хэлбэл тарифын бодлогоор үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг өндөр түвшинд авч үзжээ. Импортын барааны хамгийн өндөр гаалийн тариф БНХАУ-д 695.5 хувь, ОХУ-д 100 хувь, харин Монгол Улсад хамгийн бага буюу 40 хувь байна. Хамгийн өндөр гаалийн тарифын хувь хэмжээ харилцан адилгүй боловч, жигнэсэн дундаж тарифын хувь хэмжээ хөрш орнууд ойролцоо, Монгол улс ойролцоогоор 1.6 хувиар хөрш орнуудаас илүү байна. Энгийн дундаж тарифын хувь хэмжээ БНХАУ, Монгол Улсад ойролцоо бол, БНХАУ эдгээр хоёр улсаас ойролцоогоор 2.56 хувиар илүү байна. Энэ нь БНХАУ дэлхийн эдийн засгийн хөгжилд гол үүрэг гүйцэтгэх орон бөгөөд дэлхийд хүн амын тоогоор тэргүүлэгч, түүнчлэн тус улсын худалдааны бодлого үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ялангуяа дэлхийн үнэ цэнийн сүлжээнд гол байр эзэлдэгтэй холбоотой тул импортын энгийн дундаж тариф нь Монгол Улс, ОХУ-тай харьцуулахад өндөр байна.

БНХАУ, ОХУ нь ДХБ-д Монгол Улстай харьцуулахад хожуу элсэн орсон. Түүнчлэн аж үйлдвэр өндөр хөгжсөн тул, өөрсдийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд татварын бодлогод тун болгоомжтой ханддаг байна. Хэдийгээр ДХБ-ын гишүүнээр хожуу нэгдэн орсон хэдий ч тус байгууллагаас гаргах бодлогын баримт бичигт гол байр суурь эзэлж, өөрийн үзэл бодлыг нээлттэй илэрхийлэх, түүнчлэн хөгжиж буй орнуудад техникийн туслалцаа үзүүлэх ажлыг хэрэгжүүлж байгаа талаар ДХБ-ын тайланд тусгажээ.

Зөвхөн БНХАУ төдийгүй дэлхийн эдийн засгийн нөлөө бүхий улс орнууд ДХБ байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэгдэн орохдоо өөрийн импортын барааны гаалийн тарифын хувь хэмжээг өндөр тодорхойлдог байна. Өөрөөр хэлбэл, тухайн улс өөрийн үндэсний үйлдвэрлэл, түүний дотор ХАА, аж үйлдвэрийн салбараа хамгаалан ийнхүү тарифын хэмжээг өндөр тогтоожээ.

ДХБ²-ын гадаад худалдаа, үйлчилгээний худалдаа, гарал үүслийн дүрэм, оюуны өмч, худалдааг хөнгөвчлөх зэрэг чиглэлээр гаргасан олон улсын гэрээ, хэлэлцээр, бодлогын баримт бичгийг олон улсын хэмжээнд нэгдсэн стандартаар мөрдүүлэх, уялдуулах чиглэлийг ДГБ тодорхойлдог гэж хэлж болно. Иймд тус хоёр байгууллагын

² Гаалийн тарифаас гадна худалдааны гажилтыг зохицуулах “Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу авах демпингийн эсрэг арга хэмжээ; Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах саармагжуулах арга хэмжээ; Хамгаалалтын арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах хамгаалалтын арга хэмжээ” гэсэн гурван арга хэрэгслийг ДХБ-аас тодорхойлсон байдаг.

үйл ажиллагаа уялдаатай явагддаг болох нь олон улсын худалдааны бодлого, чиглэлээр хийсэн судалгаа, дүгнэлтээс тод харагдана.

Гарал үүслийн дүрэм: ДХБ-аас гишүүн орнуудын хооронд ямар нэгэн худалдааны саад тотгор байхгүй, худалдааг аль болох либералчлах бодлого баримтлан тус байгууллагын олон талт худалдааны системийн хэлэлцээрт үндсэн зарчмыг тусгасан байдаг. Эдгээрийн нэг нь нэн тааламжтай болон хөнгөлөлттэй гаалийн тарифыг гишүүн орнууд хоорондоо эдлэх боломж олгосон явдал юм. Иймд ДХБ-ын гишүүд хоорондоо хөнгөлөлттэй гаалийн тариф эдлэх зорилгоор Эдийн засгийн түншлэл, эсхүл Чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулан ажиллаж байна. БНХАУ 16³ бүс нутгийн болон хоёр талт (Өнөөдрийн байдлаар 8 улстай эдийн засгийн болон чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлүүлсэн), ОХУ⁴ 5 бүс нутгийн болон хоёр талт Чөлөөт худалдааны хэлэлцээр болон Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг тус тус байгуулан ажиллаж байна. Мөн Иран, Энэтхэг, Египет, Сингапур Улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлыг ОХУ 2016 онд эхлүүлжээ.

Монгол Улс Япон болон АПТА-тай чөлөөт худалдааны хэлэлцээр болон эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулсан. Монгол Улсын гааль олон улсын Конвенцод заасны дагуу гарал үүслийн улсыг тодорхойлох 2 шалгуур (“Барааг бүрэн үйлдвэрлэсэн улс” – барааг нэг улсад үйлдвэрлэсэн бол мөрдөх, “Бараанд үлэмж хэмжээний боловсруулалт хийх” - барааг хоёр буюу түүнээс дээш улсад үйлдвэрлэсэн бол мөрдөх)-ыг мөрдөхөөр, 2008 оны Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд тусгажээ. Тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар “4.5. Нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсын жагсаалтыг Засгийн газар батлах бөгөөд уг жагсаалтад хамаарах улсын гарал үүсэлтэй бараа нь гарал үүслийг нотлох баримт бичигтэй байна.”, “31.8.Гарал үүслийн гэрчилгээ заавал шаардагдах барааны жагсаалтыг Засгийн газар батална.” гэж заасан байна. Харин Эдийн засгийн түншлэлийн болон Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан улс орны хувьд уг хэлэлцээрт гарал үүслийн дүрмийг хэрхэн тодорхойлохыг тусгасан байдаг.

Тарифын бус хязгаарлалт: НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурлаас тарифын бус хязгаарлалтад хамаарах баримт бичгийг кодолсон жагсаалтыг (UNCTAD, 2019) гаргасан.

Хүснэгт 5. Тарифын бус шаардлагыг төрөлжүүлсэн бүлэг

Импорт	Техникийн арга хэмжээ	A	Эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага
		B	Худалдаан дахь техникийн саад тотгор
		C	Ачилтын өмнөх шалгалт бусад ёс журмын ажиллагаа
	Техникийн бус арга хэмжээ	D	Худалдааны хамгаалалтын арга хэмжээний хувь хэмжээ

³ БНХАУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан түнш орон: ASEAN, Сингапур, Пакистан, Шинэ Зеланд, Чили, Перу, Коста Рика, Исланд, Швейцар, Мальдив, Гүрж, Хонг-Конг, Макао, Тайван, БНСУ, Австрали.

⁴ ОХУ- Беларус- Украин- Молдав- Тажикистан- Армен- Казахстан- Кыргыз- Узбекистан, ОХУ- Украин, Евроазийн эдийн засгийн холбоо (ОХУ- Казахстан- Беларусь- Армен- Кыргыз), Евроазийн эдийн засгийн холбоо- Вьетнам, Евроазийн эдийн засгийн холбоо- Серб.

		E	Автоматжуулаагүй импортын лиценз, квот, хориглосон, чанарын хяналтын арга хэмжээ болон эрүүл ахуй, хорио цээр, эсхүл худалдаан дахь техникийн саад тотгороос бусад хязгаарлалт
		F	Үнийн хяналтын арга хэмжээ, түүний дотор нэмэлт татвар, хураамж
		G	Санхүүгийн арга хэмжээ
		H	Өрсөлдөөнд нөлөөлөх арга хэмжээ
		I	Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалт
		J	Дистербьютерийн хязгаарлалт
		K	Худалдсаны дараах үйлчилгээний хязгаарлалт
		L	Татаас болон бусад төрлийн дэмжлэг
		M	Засгийн газрын худалдан авалттай холбоотой хязгаарлалт
		N	Оюуны өмч
		O	Гарал үүсэл
	Экспорт	P	Экспортлохтой холбоотой арга хэмжээ

Эх сурвалж: *International Classification of Non-Tariff Measures (UNCTAD, 2019)*

НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурлаас гаргасан ангиллаар А, В, С нь техникийн арга хэмжээ ба А: Эрүүл ахуй хорио цээрийн шаардлага; В: Худалдаан дахь техникийн саад тотгор; С: Ачилтын өмнөх хяналт. Техникийн бус арга хэмжээг D-O хооронд ангилан 12 бүлэгт хуваасан байна.

Олон улсын худалдааны төвийн <https://www.intracen.org/> цахим хуудасны “Зах зээлд нэвтрэх” хэсгээс Монгол Улсаас экспортлох бараанд тухайн импортын оронд гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардлагатай бичиг баримт, гаалийн тарифын мэдээллийг харах боломжтой (ICT, 2021).

ДХБ-аас бэлтгэсэн БНХАУ-ын худалдааны бодлого, зохицуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.wto.org/english/tratop_e/tpr_e/tp515_e.htm линкээр орж үзнэ үү.

Асуулга 5. Дотоодын үйлдвэрийн импортыг орлох бүтээгдэхүүнийг импортын ижил төрлийн бүтээгдэхүүнтэй өрсөлдөхөд үзүүлж буй дэмжлэг, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар:

ДХБ-ын бусад гишүүдийн нэгэн адил ДХБ-д элсэн ороходоо, мөн худалдааны олон талт хэлэлцээний үеэр тарифын болон тарифын бус хязгаарлалтын талаар Монгол Улс ихэнх барааныхаа импортын гаалийн тарифыг 20%-иас илүүгүй байлгах үүрэг авсан. Мал, амьтан, үржлийн адуу, үхэр, гахай, хонь, ямаа, мэдээлэл түгээх төхөөрөмж, түүний сэлбэг хэрэгсэл, мэдээлэл боловсруулах бусад машин, диод, транзистор, эмнэлгийн төрөл бүрийн тоног төхөөрөмж зэрэг 49 нэрийн барааг 0 (тэг) хувийн гаалийн татвартай байлгах амлалт авсан байдаг. Дотоодын үйлдвэрийг ижил төрлийн импортын бараанаас хамгаалах чиглэлээр импортын гаалийн тарифын хувь хэмжээг ДХБ-ын “bound” тарифаас хэтрүүлэхгүйгээр тогтоож тарифын бодлогоор дэмжиж байна.

Нэн тааламжтай тариф. Монгол Улс ДХБ-ын гишүүн болсноор бусад гишүүн орнуудын гарал үүсэлтэй бараанд гаалийн нэн тааламжтай тариф мөрдөж байна. УИХ-аас баталсан 5%, 15%, 20%, 25%, 35%, 40%-ийн импортын гаалийн татварууд нь нэн тааламжтай тариф болно. Ердийн тариф нь нэн тааламжтай тарифаас 2 дахин их байна. Хөнгөлөлттэй тарифыг Монгол-Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу Японы гарал үүсэлтэй бараанд, мөн Ази Номхон Далайн Худалдааны Хэлэлцээрийн дагуу Бангладеш, БНХАУ, БНСУ, Лаос, Шри Ланка, Энэтхэг улсаас гарал үүсэлтэй бараанд мөрдөж байна.

Импортын барааны гаалийн тарифын хувь хэмжээг “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоол, УИХ-ын эрх олгосноор Засгийн газрын “Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай” 2015 оны 08 дугаар сарын 17-ны тогтоол, Засгийн газрын “Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай” 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн тогтоолын хүрээнд импортын барааны гаалийн нэн тааламжтай тарифыг мөрдөж байна.

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор УИХ, ЗГ-аас тогтоосон зарим барааны гаалийн нэн тааламжтай тарифын хувь хэмжээ

БТКУС Код	Барааны бичиглэл	Албан татварын хувь, хэмжээ
0407	Шувууны өндөг	15
0409	Зөгийн цэвэр бал	10
16.01	Мах, дайвар мах эсхүл цусаар хийсэн хиам болон түүнтэй төстэй бүтээгдэхүүн; тэдгээрээр хийсэн хүнсний бэлдмэл	15
0204	Хонь, ямааны шинэ, хөргөсөн эсхүл хөлдүү мах	15
0205	Адууны мах:	15
0206	Үхрийн мах	15
0207	Тэмээний мах	20
0401	Саахар болон бусад амтлагчийн хольцгүй, шингэн сүү, цөцгий	15
0701	Шинэ, эсхүл хөргөсөн төмс	20
2105	Какао агуулсан, эсхүл агуулаагүй зайрмаг, хүнсний зориулалтын бусад мөсөн бүтээгдэхүүн	15
2203	Шар айраг	25
22.04	Усан үзмийн цэвэр дарс	20
22.06	Исгэсэн бусад ундаа	20
2208.60	Цагаан архи	40
2208.70	Ликёр болон кордиал	40
25.23	Өнгө оруулсан эсхүл оруулаагүй, клинкер хэлбэрт оруулсан буюу оруулаагүй, портланд цемент, пуйлсаган цемент (хөнгөн цагаант цемент), шаарган цемент, суперсульфатын цемент болон тэдгээртэй төстэй усжсан цемент	20%
3925	Барилгын зориулалттай, бусад газар заагдаагүй хуванцар зүйлс	6.5

	Хаалга Цонх	
4418.20	Хаалга, хаалганы хүрээ мод, босго:	20
4910	Бүх төрлийн хэвлэмэл хуанли (тасалбар хуанли орно).	20
4911.10	Худалдааны зар сурталчилгааны материал болон барааны каталог, түүнтэй төстэй бусад материал	20
5106	Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, хонины сэмлэсэн ноосон ээрмэл	10
560221	Хонины ноос, эсхүл мал, амьтны нарийн үс, ноосон	20
630532	Дамжлагын бөөний савлагааны зориулалттай, их даацын уян шуудай	20
640340	Хамар нь металл хамгаалалттай бусад гутал	20
68101110	Барилгын блок	15
68101120	Силикат тоосго	10
690410	Барилгын тоосго	20
940330	Албан газрын зориулалттай модон тавилга	20

Асуулга 6.Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр Монгол Улсын хоёр болон олон талт гэрээний хэрэгжилтийн өнөөгийн байдал, тэдгээрийн Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй зэрэг нөлөө, давуу болон сул тал, хэрэгжүүлэх явцад тулгарч буй саад бэрхшээл, түүнийг даван туулахад худалдаа, тээврийг хөнгөвчлөх талаар ямар арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай талаар:

ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилт: Монгол Улсын Их Хурал ДХБ-ын “Худалдааг хөнгөвчлөх” хэлэлцээрийг 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр соёрхон баталснаар худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаа үндэсний хэмжээнд анхаарал хандуулах чухал асуудлын нэг болсон. Иймд хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах, салбар дундын зохицуулалт хийх үндсэн үүргийг хэрэгжүүлэх “Үндэсний хороо”-г байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 137 дугаар тогтоолоор байгуулсан.

Улмаар “Үндэсний хороо”-ны Дүрэм болон бүрэлдэхүүнийг баталж, хорооны хуралдааныг тогтсон хугацаанд зохион байгуулан ажиллаж байна.

Энэхүү хэлэлцээр нь худалдааг хөнгөвчлөх талаар шинэ асуудал хөндөж буй хэрэг биш билээ. Гадаад худалдаа нь улс орны хөгжлийн түлхүүр тул ДГБ, ДХБ, НҮБ-ын Европын Эдийн Засаг Нийгмийн Хороо, Европын Холбоо, Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сан болон бусад олон улсын байгууллагаас худалдааг хөнгөвчлөхтэй холбоотой баримт бичгийг өмнө нь гаргасан байдаг.

ДГБ-аас “ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн I хэсгийг хэрэгжүүлэх заавар”-ыг 2014 онд гарган, гишүүн орнуудын туршлагаар байнга баяжуулж байна. Энэхүү зааврын гол зорилго нь ХХХ-ийн хэрэгжилтийг хангахдаа ДГБ-аас худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гаргасан бодлогын баримт бичигтэй уялдуулан хэрэгжүүлэх боломж олгох явдал юм. Уг зааварт ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн заалт тус бүрээр “Ерөнхий тойм; Хэлэлцээрийн заалт; ДГБ-ын Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцын уг заалттай холбоотой стандарт, гарын авлага; ДГБ-аас гаргасан

бусад бодлогын баримт бичиг; Гишүүн орнуудын туршлага болон гүйцэтгэлийн шалгуур”-ыг тусгасан байна (WCO, 2014).

Монгол Улс тус хэлэлцээрт нэгдэн орох үед авсан үүрэг амлалтаар хэлэлцээрийн хэрэгжилт **23.5 хувьтай** байсан бол өнөөдрийн байдлаар **79.9 хувьтай** байна⁵.

Худалдааг хөнгөвчилснөөр Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй эерэг нөлөө, давуу талын хувьд үндэсний хэмжээнд энэ асуудал тэргүүлэх чиглэл болсныг онцлох нь зүйтэй. Өмнө өгүүлсэнчлэн зөвхөн энэ хэлэлцээр нь дэлхийн хэмжээнд худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааг зохицуулсан гэж үзэхгүй талаар өмнө өгүүлсэн. Өөрөөр хэлбэл Монгол Улсын нэгдэн орсон худалдаа, тээвэртэй холбоотой бусад гэрээ, хэлэлцээр, бодлогын баримт бичигт тусгалаа олсон.

Хүндрэлтэй асуудал, саад бэрхшээл: Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад ихэнх нь гадаад худалдааны болон эдийн засгийн яамтай тул худалдааг хөнгөвчлөх бодлого, чиглэлийг манлайлан хэрэгжүүлдэг. Харин Монгол Улсын хувьд хөнгөн үйлдвэрийн бодлого ХХААХҮЯ, хүнд үйлдвэрийн бодлого УУХҮЯ, гадаад худалдааны бодлого ГХЯ-д тус тус харьяалагдаж байна. Энэ нь төрийн байгууллагын уялдаа холбоог хангах, төрийн давхардсан хяналтыг бууруулах, цахим харилцаа холбоо бий болгох хэрэгцээ шаардлагыг бий болгон, Монгол Улсын ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэхэд Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна. Өнөөдрийн байдлаар худалдааг хөнгөвчлөх арга хэмжээний үр дүнг тооцоход дараах хүндрэлтэй асуудал тулгараад байна. Үүнд:

- Цахим харилцаа, холбоог хөгжүүлэх;
- Гамшгийн үед гадаад худалдааны тасралтгүй байдлыг хангахтай холбоотой бэлэн байдал, Төр-Хувийн хэвшил болон Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны механизм хөгжөөгүй;
- Дэд бүтцийн хөгжил, худалдаа, тээврийн салбарын тус тусдаа бие даасан бодлого;
- Худалдааны түнш орнуудтай хилийн хяналтыг уялдуулах, худалдаа, тээврийн мэдээллийг экспортлох үеэс солилцох боломжгүй;
- Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг хөгжүүлээгүй гэх мэт.

Түүнчлэн дэлхийн хэмжээнд КОВИД-19 вируст халдвар цар тахлын хэмжээнд хүрч, худалдаа, тээвэр, аялал жуулчлал, түүнчлэн бусад салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх болсон.

Сүүлийн гурван жилд олон улсын худалдааны бараа нийлүүлэх сүлжээнд дэлхийн хэмжээнд үүсээд байгаа нөхцөл байдал, Монгол Улсын Алсын хараа-2050 баримт бичиг зэрэгтэй уялдуулан Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “Эдийн засаг, хөгжлийн яам”, “Цахим хөгжил, харилцаа холбооны яам”-ыг шинээр байгуулж, Гаалийн ерөнхий газарт Хилийн

⁵ Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд 2021 онд “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн 6 заалт (1.3. Лавлах цэг; 2.1. Санал өгөх боломж олгох, хүчин төгөлдөр болохоос өмнө мэдээлэл өгөх; 5.1. Хяналт, шалгалтыг чангатгах талаар мэдэгдэл хүргүүлэх; 7.2. Цахим төлбөр; 7.9. Түргэн мууддаг бараа; 10.5. Ачилтын өмнөх шалгалт)-ын биелэлтийг хүргүүлсэн.

мэргэжлийн хяналтын албыг нэгтгэсэн нь худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг шинэ шатанд гаргахад дэмжлэг болох юм.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэн **худалдаа, тээврийн үйл ажиллагааг хөнгөвчлөх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэх саналтай байна.** Үүнд:

- Худалдаа, тээврийн урсгалыг саадгүй нэвтрүүлэх, төрийн давхардсан хяналтыг бууруулах, ил тод, нээлттэй, цахим үйл ажиллагааг дэмжсэн, тодорхой эрх зүйн зохицуулалтыг бий болгох. Гэнэтийн нөхцөл байдалд түргэн хугацаанд шинэчлэх боломжийг эрх бүхий байгууллагад олгох;
- Худалдаа, тээврийг хөнгөвчлөх чиглэлээр үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд мониторинг хийх;
- Хөрш орнуудын гаалийн байгууллага, гадаад худалдааны түнш орнуудтай гаалийн хамтарсан хяналт хэрэгжүүлэх цар хүрээг гаалийн мэдүүлэг, тээврийн бичиг баримт солилцох, гаалийн хяналтыг харилцан хүлээн зөвшөөрөх, хилийн хяналтын байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар үйл ажиллагааны горимоо ижилтгэх (Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээрийн Зүйл 7, 8, 12 дугаар зүйл) ажлыг зохион байгуулах;
- Үндэсний хэмжээнд хамтарсан эрсдэл тооцох механизмыг бүрдүүлэх. Өндөр эрсдэл бүхий ачилтыг экспортлогчийн нутаг дэвсгэрээс хянах нь гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, улмаар хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх ач холбогдолтой (Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээрийн Зүйл 7.4 Эрсдэлийн удирдлага);
- Хөнгөлөлттэй гаалийн тариф эдлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар гадаад худалдааны бараа эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор эдийн засгийн түншлэлийн, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг байгуулах;
- Монгол Улсаас хөрш орнуудаар дамжин гуравдагч оронд хүрэх экспортын, эсхүл гадаадын өөр орноос хөрш орнуудыг дамжин ирэх импортын ачилтын үйл ажиллагааг Дэлхийн Гаалийн Байгууллагын Мэдээллийн өгөгдлийн загвартай уялдуулан дамжин өнгөрөх ачилтыг үйл ажиллагааг хялбаршуулах (Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээрийн Зүйл 10.3. Олон улсын стандарт ашиглах).
- Хөрш орнуудын олон улсын худалдааны “Нэг цонх”-ны системийг хөгжүүлсэн туршлагыг судлах, бүс нутгийн “Нэг цонхны систем” хөгжүүлэх арга замыг эрэлхийлэх (Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээрийн Зүйл 10.4. Нэг цонхны систем);
- Хил дамнан халдварладаг малын гоц халдварт, халдварт өвчний мэдээллийг харилцан шуурхай солилцдог механизмыг хөгжүүлж, мал эмнэлгийн салбарт хамтарсан платформ байгуулах. Энэ төрлийн эрсдэл бүхий нөхцөл байдал арилсан тохиолдолд хорио цээрийн хориглолт, хязгаарлалтыг нэн даруй цуцлах механизмыг судлан хэрэгжүүлэх;
- Худалдааны түнш орнуудтай мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний худалдааг хөнгөвчлөх, хоёр талын эрүүл ахуйн шаардлага, нөхцөлийг нэн даруй тохирч, худалдааны эрх зүйн орчныг бүрдүүлэхэд хамтран ажиллах;
- Улсын хилээр түргэн муудах, амархан гэмтэх, онцлог болон хөдөө аж ахуйн гаралтай барааг тэргүүн ээлжид бүрдүүлэлт хийх, шилжүүлэн ачих тусгай гарцыг хоёр талд бий болгох. Үүнийг “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх” Логистикийн төвийн үйл ажиллагаатай уялдуулах;

- Дэд бүтцийг хөгжүүлэх, сайжруулах, дамжин өнгөрөх эрх чөлөөг ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 11 дүгээр зүйлд заасны дагуу хөрш орнуудын нутаг дэвсгэрт эдлэх боломжийг хөрш орнуудын засгийн газрын түвшний уулзалтад тусгах, хэрэгжүүлэх;
- Хилийн хамтарсан шалгалтыг хөрш орнуудтай нэвтрүүлж, цаасгүй худалдаа, хяналтын ижилтгэсэн баримт бичиг хэрэглэх;
- Хилийн хяналтын байгууллагуудын мэргэшсэн байдлыг хадгалах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, байгууллагын үйл ажиллагааг шинэчлэх, хилээр нэвтрэх үйл ажиллагааг сайжруулах, мэдээллийн урсгал, бичиг баримтын шаардлагыг уян хатан болгох;
- БНХАУ-ын Гаалийн Ерөнхий Газар Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар Хооронд байгуулсан “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэн, нэн тэргүүнд итгэмжлэгдсэн экспортлогч, тээвэрлэгчийн хөтөлбөрийг нэвтрүүлэх стратегийн түвшний дэмжлэг авах ажлыг зохион байгуулах. Одоогийн байгуулсан хэлэлцээр нь агентлагийн даргын түвшинд тул хоёр орны тээвэр, худалдааны асуудал хариуцсан яамдыг оролцуулан итгэмжлэгдсэн тээвэрлэгч хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх;
- Гурван улсын гаалийн байгууллага хооронд худалдааны хөгжлийг дэмжих таатай нөхцөл бүрдүүлэх хүрээнд хамтран ажиллах тухай Санамж бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгуулсан “Зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Гааль, Татварын Ерөнхий Газар, ОХУ-ын Холбооны Гаалийн Алба болон БНХАУ-ын Гаалийн Ерөнхий Газар хоорондын Хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх. Ялангуяа гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх барааны нэр төрлийн сонголтыг нэмэгдүүлэх, Монгол Улсад ижил байдлаар ашиг хүртэх нөхцөлийг бүрдүүлэх ажлын хэсэг байгуулж хэлэлцээрт нэмэлт оруулах, хэрэгжилтийг хангах;
- БНХАУ-тай байгуулсан Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай барааны хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг зохицуулсан баримт бичгийн хэрэгжилт удаашралтай, үр дүнгүй, цаасан дээр хөгжсөн тул хоёр талаас ажлын хэсэг гарган одоогийн байгуулсан бүх баримт бичгийн хэрэгжилтэд мониторинг хийх. Цаашид тогтмол хугацаанд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангах, цахим болон биет байдлаар хамтран ажиллах боломжийг судлах. Түүнчлэн гурван талт, хоёр талт, стратегийн түншлэл, хилийн боомтын дэд бүтэц, гаалийн хамтын ажиллагаа зэрэг баримт бичигт энэ чиглэлийг хөгжүүлэх асуудал давхардан орсон тул ойрын үед талууд цахим, эсхүл биет байдлаар уулзан, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөрт шигтгэн оруулах;
- Хөрш орнуудтай цахим хэлбэрээр гадаад худалдааны мэдээллийг солилцох ажлыг шинэ шатанд гаргах.
- Гадаад худалдааны хуультай болох;
- БНХАУ-ын үйлдвэрлэлийн шилдэг технологийн тусламжтай Монгол Улсын хүний, газар зүйн, түүхий эдийн нөөцийг ашиглан “Барааг дотоодод болон гадаадад боловсруулах гаалийн горим”-ын дагуу уул уурхайн бус гаралтай барааны экспортыг нэмэгдүүлэх ажлыг гадаадын хөрөнгө оруулалтаар дэмжин, үе шаттайгаар зохион байгуулах (Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээрийн Зүйл 10.9. Түр хугацаагаар нэвтрүүлэх болон дотоодод, гадаадад боловсруулах).

ДХБ-д 2022 онд хүргүүлсэн Худалдааг хөнгөвчлөх арга хэмжээний хэрэгжилт

Нэг. Зүйл 1.1 Хэвлэн нийтлэх

“Гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах” чиг үүргийн дагуу Гаалийн байгууллагын албан ёсны вэб хаягт энэхүү арга хэмжээнд тусгасан 10 мэдээллийг оруулж хэвшсэн.

- БТКУС-ийн жагсаалт, Гадаад худалдааны статистик мэдээллийг цаас болон цахим хэлбэрээр хэвлэн нийтэлдэг. Импорт, экспорт, дамжуулан өнгөрүүлэх үйл ажиллагаатай холбоотой үндэсний хэмжээнд хууль тогтоомжийг нэгтгэсэн эмхтгэл, эсхүл дангаар цахим хэлбэрээр гаалийн байгууллагын цахим хуудсаар түгээдэг;
- Гаалийн байгууллагын цахим хуудсыг хөгжүүлэх, мэдээ, мэдээлэл байршуулах, цахим хуудасны хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангахад чиглэсэн харилцааг зохицуулах Цахим мэдээ, мэдээлэл хүлээн авах түгээх журмыг Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар 2013 онд баталсан
- Гаалийн хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг Засгийн газрын “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ын дагуу цаасан хэлбэрээр хэвлэн нийтэлж түгээдэг;
- Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд гадаад худалдаа эрхлэхтэй холбоотой мэдээллийг аливаа нэгэн хязгаарлалтгүйгээр сонирхогч этгээд хүлээн авах боломжтой.

Гадаад худалдаанд оролцогч яам, агентлаг, байгууллагын “хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах” асуудал хариуцсан нэгж гадаад худалдаатай холбоотой мэдээллийг хэвлэн нийтлэх үүрэг хүлээсэн.

Хоёр. Зүйл 1.2 Интернетээр дамжуулан авах боломжтой мэдээлэл

- Төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийг баталсан.
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн www.legalinfo.mn цахим хуудаст Гадаад худалдаа, гаалийн хяналтын үйл ажиллагааг зохицуулсан хууль эрхийн актууд цахимаар нийтлэгдэж хэвшсэн;
- Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолын хавсралт “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ын 3.1-д заасны дагуу байгууллага нь албан ёсны цахим хуудсыг үүсгэж, хуульд заасан мэдээллийг ойлгомжтой байдлаар байрлуулж, олон нийтэд түгээж байна.
- Засгийн газар болон УИХ-аас гаргасан хууль тогтоомжийг “Төрийн мэдээлэл сэтгүүл”-д хэвлэн нийтэлдэг. Мөн эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэгддэг ба дээрх мэдээллийг ихэнх байгууллагууд монгол хэл дээр хэвлэн нийтэлдэг. Монгол Улсын “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан (Mongolia Trade portal)”-г 2020 оны 12 дугаар сард Дэлхийн банк (ДБ) группийн Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-тай хамтын ажиллагааны хүрээнд бий болгосон.

Гурав. Зүйл 7.1 Бичиг баримтын бүрдүүлэлтийг бараа ирэхээс өмнө хийлгэх

- Гаалийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу илгээгч улсын нутаг дэвсгэрээс ачигдсан гадаадын барааг Монгол Улсын хилээр оруулахаас өмнө, эсхүл хилийн гаалийн байгууллагын хяналтаас гүний гаалийн байгууллагын хяналтад орохоос өмнө тус тус урьдчилан мэдүүлж, бараа ирсний дараа бичиг баримтын эх хувийг хуулбартай тулгаж шалгаж гаалийн бүрдүүлэлт хийж байна.
- Гаалийн тухай хуулийн 27 дугаар зүйлд “Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримт”-ын талаарх зохицуулалтыг тусгасан. Мөн хуулийн 27.6 дахь хэсэгт заасны дагуу гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах бичиг баримтыг цахим хэлбэрээр ирүүлж болно.

Дөрөв. Зүйл 7.3 Бараа олгох ажиллагааг гаалийн болон бусад татварыг, мөн төлбөр, хураамжийг эцэслэн тодорхойлох ажиллагаанаас ялган салгах

- Засгийн газрын 2009 оны 89 дүгээр тогтоолын дагуу хэрэв бараа ирэхээс өмнө, эсхүл ирэх үед тодорхойлсон гаалийн болон бусад татварыг төлсөн, хэсэгчлэн төлсөн, эсхүл тэдгээрийг төлөх баталгааг үндэслэн хойшлуулсан тохиолдолд барааг олгож байна.
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 39, 40, 41 дүгээр зүйлд энэ талаар тусгасан. Мөн хуулийн “41.4.Гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргах журмыг Засгийн газар батална” гэж заасан. Үүний дагуу Засгийн газрын 2009 оны 89 дүгээр тогтоолоор гаалийн болон бусад татвар, төлбөр, хураамжийг тодорхойлсны дараа гаалийн болон бусад татварыг хойшлуулах, хэсэгчлэн төлөх, баталгаа, барьцааг үндэслэн барааг олгох боломжийг бүрдүүлсэн.

Тав. Зүйл 7.4 Эрсдэлийн удирдлага

- Гаалийн тухай хуулийн 233.2; 240.2; 268.1.3 дугаар заалтад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх талаар тусгасан. ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар барааг оруулах, гаргах болон дамжуулан өнгөрүүлэхэд “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ыг баталсан.
- ГЕГ-ын даргын 2019 оны А/287 тоот тушаал болох Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам, Гаалийн хяналтын стратегид гаалийн эрсдэлийн удирдлагын бодлого, чиглэлийг тусгасан.
- Хуулийн хүрээнд эрсдэлийн удирдлагыг гаалийн хяналтад нэвтрүүлэх боломж бүрдсэн хэдий ч Монгол Улсын Засгийн газрын 2021 оны шийдвэрийн дагуу хил дээр гааль, мэргэжлийн хяналт нэгдэн ажиллах шаардлагатай тул сайжруулах, уялдуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Зургаа. Зүйл 7.6 Бараа олгох дундаж хугацааг тогтоож, хэвлэн нийтлэх

- Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг Гаалийн удирдах төв байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусган ДГБ-ын Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны дагуу 2010 оноос эхлэн хийсэн;
- Эхний судалгааг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ын тусламжтай Гааль, Мэргэжлийн хяналт, Хил хамгаалах байгууллагаас ажлын хэсэг гарган хийсэн;
- Улмаар ДГБ-аас Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийх чиглэлээр техникийн туслалцаа авч албан хаагч нараа мэргэшүүлсэн. Ийнхүү бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийх бодлого, чиглэл зөвхөн Гаалийн байгууллагаар хязгаарлагдахгүй, хилийн бусад агентлагын анхаарах асуудлын нэг болсон;
- Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг 2010, 2012, 2014, 2017, 2019 онуудад хийсэн;

- ДБ группийн ОУСК-ийн тусламжтайгаар 2019 онд Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг сонгон авсан хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсийн хүрээнд хийсэн.
- Гаалийн автоматжуулсан системд бүрдүүлэлтэд зарцуулсан цаг хугацааг автоматаар бүртгэх боломжтой. Үүнтэй уялдуулан гаалийн газар, хороо, гаалийн хяналтын бүс, бараагаар бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг тодорхойлон гаргаж, өөрийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилладаг.

Долоо. Зүйл 7.7 Итгэмжлэгдсэн операторуудад зориулсан худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ

- Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 271.1.16 дүгээр хэсэгт Гаалийн байгууллагын удирдлагын бүрэн эрхэд “улс хоорондын худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, олон улсын стандартын дагуу гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан тохиолдолд гаалийн харилцаанд оролцогчид гаалийн итгэмжлэл олгох” гэсэн заалтыг хуульчилж өгсөн байдаг.
- Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид дараах 9 төрлийн хөнгөлөлт үзүүлэх эрхийг заасан (ГЕГ-ын даргын 2021 оны А/118 дугаар журам: Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журмын 3.1). Үүнд:
 - барааг эзэмшигчийн байр, агуулах, талбайд түр хадгалах;
 - бараанд хийх шалгалтаас чөлөөлөх;
 - гаалийн болон бусад татвар төлөх хугацааг сунгах боломжийг олгох;
 - багцалж гаалийн нэг мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлтийг хийх боломжийг олгох;
 - туслалцаа үзүүлэх үүрэг бүхий гаалийн улсын байцаагчийг тусгайлан томилох;
 - итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн талаар олон нийтэд сурталчлах;
 - гаалийн бүрдүүлэлтийг барааны байршлаас үл хамааран аль ч гаалийн байгууллагад хийх;
 - итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулсан бусад улс оронд хөнгөлөлт эдлэх.
- ИААН-ийн хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй танилцуулгыг Гаалийн байгууллагын албан ёсны веб хуудаст байршуулсан бөгөөд холбогдох журмын линкийг зааж өгсөн байдаг;
- ГЕГ-ын даргын баталсан холбогдох журамд итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид 4 төрлийн нийт 29 шалгуур тавихаар тодорхойлж өгсөн байдаг;

Найм. Зүйл 7.9 Түргэн мууддаг бараа

- Гаалийн тухай хуулийн Дагуу дараах нэр төрлийн барааг түргэн мууддаг бараа хэмээн тодорхойлсон:
 - 29.1.6.амархан муудах, гэмтэх магадлал бүхий хадгалалтын онцгой нөхцөл шаардсан бараа;
 - 29.1.7.донорын эд эрхтэн, цус, цусан бүтээгдэхүүн;
 - 29.1.8.хуульд заасан бусад бараа
 - Гаалийн тухай хуулинд “Гаалийн бүрдүүлэлтийг гаалийн байгууллага бүхий газарт, гаалийн удирдах төв байгууллагын даргаас тогтоосон цагт хийнэ” гэж тусгасан. Гэсэн хэдий ч тогтоосон ажлын цагт хийх боломжгүй бол захиалга, дуудлагаар гаалийн бүрдүүлэлт хийх боломжтой.;
- 286.3.Гаалийн бүрдүүлэлтийг энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд хийх боломжгүй тохиолдолд гаалийн газар, хорооны даргын шийдвэрээр гаалийн улсын байцаагчийг

ажлын бус цагаар ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд гаалийн байцаагчид Хөдөлмөрийн тухай хуульд заасан журмын дагуу илүү цагийн хөлс олгоно.

Ес. 10.9.1. Барааг түр хугацаагаар оруулах, барааг дотоодод болон гадаадад боловсруулах

- Барааг түр хугацаагаар оруулах , барааг дотоодод болон гадаадад боловсруулах Гаалийн тухай хуулийн 93-98 , 99-107 , 125-131 дүгээр зүйл , ГЕГ - ын даргын 2016 оны А/ 40 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан " Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам " , 4 дүгээр хавсралтаар батлагдсан " Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам " , ГЕГ - ын даргын 2016 оны А / 41 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан " Барааг хилийн чанадад боловсруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам " -аар тус тус зохицуулагдаж байна .
- Гаалийн тухай хуулинд барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулахад гаалийн болон бусад татварыг төлж , барагдуулан төрийн сангийн түр дансанд байршуулж байгаад , бараанд аливаа өөрчлөлт орохгүйгээр буцаан гаргасан тохиолдолд түр дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг буцаан олгоно гэж заасан байдаг .

Асуулга 7.Дамжин өнгөрөх тээврийн болон тарифын хөнгөлөлтийн талаарх нийт хэлэлцээр, тохиролцоо, мөн ДХБ-д элссэнтэй холбогдуулан Засгийн газрын дамжин өнгөрөх тээврийн талаар хүлээсэн үүрэг, тэдгээрийн хэрэгжилтийн талаар:

ДХБ-ын хувьд гишүүд хоорондын дамжин өнгөрөх тээвэртэй холбоотой асуудлыг ДХБ-ын ТХЕХ-ийн 5 дугаар зүйлийн дагуу зохицуулна. Энэхүү заалтын дагуу тус байгууллагын гишүүдийн хувьд өөрийн улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийн хэрэгсэлийг аль болох тохиромжтой замаар чөлөөтэй өнгөрүүлж, аливаа нөхцөл байдалд ялгавартай хандахгүй байхаар заасан. Мөн тээвэрлэлтийн болон тээврээс үүдэн гарах захиргааны зардал, эсхүл үзүүлсэн үйлчилгээний хураамжаас бусад хураамжийг тээврийн хэрэгсэлд ногдуулахгүй байхаар журамласан байна.

Дээр дурдсанчлан, ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрээр экспорт, импорт мөн дамжин өнгөрөх барааны урсгалыг саадгүй, шуурхай нэвтрүүлэх, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хил, гаалийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах асуудлыг зохицуулдаг.

"ТИР карней ашиглан барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенц"-ын дагуу гаалийн нутаг дэвсгэрт оруулах, түүнээс гаргах болон нутаг дэвсгэрээр дамжуулах барааг олон улсын хэмжээнд гаалийн битүүмжлэлтэй авто тээврийн хэрэгслээр тээвэрлэх зохицуулалт бий болсон.

Монгол Улсын бараа бүтээгдэхүүний дамжин өнгөрөх тээвэрлэлтэд ОХУ, БНХАУ-тай хийсэн гурван талт болон хоёр талт хамтын ажиллагааны тохиролцоонууд чухал үүрэгтэй. Тухайлбал,

Гурван талт зохицуулалтын хүрээнд:

- Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэр гүйцэтгэх тухай Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /Монгол Улс 2018.04.13-нд соёрхон баталсан/;
- Монгол, Орос, Хятадын "Эдийн засгийн коридор байгуулах" хөтөлбөр /2016.06.23/;

- Монгол Улс, ОХУ болон БНХАУ-ын хоорондын худалдааг дэмжих таатай нөхцөл бүрдүүлэх хүрээнд хамтран ажиллах тухай Монгол Улсын Гаалийн ерөнхий газар /ГЕГ/, ОХУ-ын Холбооны гаалийн алба /ХГА/, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар /ГЕГ/хоорондын санамж бичиг /2015.07.09/;
- Зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын ГЕГ, Татварын ерөнхий газар, ОХУ-ын ХГА, БНХАУ-ын ГЕГ хоорондын хэлэлцээр /2016.06.23/.

Хоёр талт зохицуулалтын хүрээнд /БНХАУ, ОХУ-тай/:

- Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1993.09.07/;
- Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээр /2011.06.16/;
- Монгол Улс Хятад Улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /2014.08.21/;
- Төмөр замын тээврийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг /2014.08.21/;
- Монгол Улс, ОХУ-ын нутгаар дамжин тээвэр хийж, далайд гарах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1992.10.19/;
- Гаалийн асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1993.01.20/;
- Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1996.02.07/;
- Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /2018.06.08/;
- Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /2019.09.03/;
- Зарим нэр төрлийн бараанд хийх гаалийн хяналтын үр дүнг цахим хэлбэрээр харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын протокол /2012.12.16/ зэрэг болно.

Асуулга 8.Цаашид Монгол Улсын бараа, бүтээгдэхүүнийг ОХУ, БНХАУ-д экспортлох боломжийг нэмэгдүүлэх, Ази, Европыг холбосон газар зүйн байршлын давуу талаа ашиглан “Транзит Монгол” болох, гурван улс эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж хамтдаа хожиж, хамтдаа хөгжихөд онцгой ач холбогдолтой БНХАУ-ын Эрээнээс Сайхан тал, ОХУ-ын Хиагтаас Улаан-Үд-Эрхүү хүртэлх төмөр замын суурь бүтцийг өргөтгөх чиглэлээр улс төр, эдийн засгийн ямар яриа хэлэлцээ өрнүүлж буй талаар:

Монгол Улсын бараа, бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортлох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр хилийн төмөр замын боомт шинээр байгуулах ажлыг хятадын талтай эрчимжүүлээд байна.

Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрт 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж шинээр Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч төмөр замын 3 боомт байгуулах суурь эрх зүйн үндэс бүрдсэн.

Сүүлийн 7 жилийн туршид тохиролцож чадахгүй байсан Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод төмөр замын боомтын хил огтлох цэгийг 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр тохиролцож хэлэлцээр байгуулсан.

Хилийн Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхэ төмөр замын боомтын бүтээн байгуулалтын ажлыг 2022 онд эхлүүлж, Шивээхүрэн-Сэхэ төмөр замын боомтыг энэ жилдээ, Гашуунсухайт-Ганцмод төмөр замын боомтыг 2024 онд барьж дуусгахаар ажиллаж байна.

Мөн 2022 онд Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт Ханги-Мандал төмөр замын боомтыг нэмж тусгахаар ажиллаж байна.

Үүний зэрэгцээ одоо байгаа БНХАУ-ын Эрээн төмөр замын боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөл, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлэх хүсэлтийг хоёр улсын төрийн байгууллагуудын бүх түвшний уулзалт, хэлэлцээнд тавьж ирсэн.

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нар “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг 2016 онд 5 жилийн хугацаатайгаар баталсан. Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт гурван улсын нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын хамтын ажиллагааг хамарсан нийт 32 төсөл байдгаас тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх асуудал гол байр суурь эзэлж ирсэн.

“Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх гурван талын ажлын хэсгийн шинжээчдийн түвшний 5-р уулзалт 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдсан. Төмөр замын “Төв” коридор (Улаан-Үүд – Наушки – Сүхбаатар – Улаанбаатар - Замын-Үүд – Эрээн - Жинин)-ыг шинэчлэн хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэлийн ажлыг эхлүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл, Ажлын төлөвлөгөөний төсөл 2021 онд бэлэн болсон ба талууд хөтөлбөрийг 5 жилээр сунгах асуудлыг хэлэлцэж дэмжихээр болсон. Ажлын төлөвлөгөөнд тусгаснаар Техник, эдийн засгийн үндэслэлийн ажлыг 2023 онд дуусгахаар заасан.

Энэхүү төмөр замын “Төв” коридорыг шинэчлэн хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэнээр төслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, барилгын ажлыг эхлүүлэх боломжтой болно.

Мөн төмөр замын “Баруун” коридор байгуулах эрх зүйн үндэс бүрдүүлж Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод Улсын Их Хурлын 2021 оны 82 дугаар тогтоолоор Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45,5 км төмөр замыг Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1255 км төмөр зам болгон тусгасан.

-----oOo-----